



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠰᠡᠯᠡᠨᠭᠡ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2017/12



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХААНААС, ХЭРХЭН АВАХ ВЭ?

WWW.NSO.MN



Цахимаар:



Энэ сайтад өөрийн e-mail хаягаа бүртгүүлснээр статистикийн мэдээллийг цаг алдалгүй тогтмол авч байх болно.

SOCIAL NETWORK



www.facebook.com/Статистик-Мэдээлэл

www.selenge.nso.mn

Сэлэнгэ аймгийн статистикийн хэлтсийн веб хуудас



Утсаар:

Лавлах утас:
1900-1212



СЭЛЭНГЭ АЙМАГ

www.facebook.com/Сэлэнгэ Статистик



Сэлэнгэ аймаг

70362047
70362449
70363694



Ухаалаг гар утас, таблет ашиглан статистик мэдээлэл авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл бүтээгдэхүүнийг унших Монетаг аппликейшн





СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	4
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР.....	5
ТОВЧ АГУУЛГА.....	7
1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР.....	23
2. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	24
2.1 ХҮН АМ.....	24
2.2 ЭРҮҮЛ МЭНД.....	39
2.3 БОЛОВСРОЛ.....	43
2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ.....	52
2.5 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ.....	55
2.6 ГЭМТ ХЭРЭГ.....	56
2.7 ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД.....	59
3. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	60
3.1 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, МӨНГӨ, ЗЭЭЛ.....	60
3.2 МӨНГӨ БАНК.....	61
3.3 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР.....	63
3.4 ГАДААД ХУДАЛДАА.....	68
3.5 ҮНЭ.....	68
4. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	72
4.1 БИЗНЕС РЕГИСТР.....	72
4.2 ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	73
4.3 АЖ ҮЙЛДВЭР.....	96
4.4 АВТО ТЭЭВЭР.....	99
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛ.....	103
6. БУСАД.....	106



Ерөнхий тэмдэглэл

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
ГХ- Гэмт хэрэг
ХАА- Хөдөө аж ахуй
АҮ - Аж үйлдвэр
ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
СЭ - Сэлэнгэ
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
... Мэдээлэл байхгүй
Х Бүтцийн өөрчлөлт
0.0 Маш бага тоо
+, - Зөрүү
- Гүйцэтгэл байхгүй
* Дахин
"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Суурин хүн ам: Тухайн Засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг харуулдаг.

Хүн амын тоо. Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

Суурин хүн ам. Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.

Өрх. Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ.

Хүйсийн харьцаа. Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

Хүн ам зүйн ачаалал. Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.

Хүн амын нас-хүйсийн суварга. Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсний ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.

Орон сууцны байшин. Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалтай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ.

Бие даасан тохилог сууц. Бие даасан сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалтай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж болон холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.

Төсөв: Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Зээл: Гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгийг

Ажилгүйчүүд: Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.



Үнэ: Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс: Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Гэмт хэрэг: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

Хээлтэгч мал: Нас гүйцсэн эм малыг хамруулна.

Зүй бусаар хорогдсон малын тоонд: Халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Аж үйлдвэр: Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

**ТОВЧ АГУУЛГА****Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**
(2017 оны жилийн эцсийн байдлаар)**1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР****1.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж**


Сэлэнгэ аймаг нь 17 сум, 56 багтай. Үүнээс Тосгоны статустай Дулаанхаан, Бугант, Номгон, Рашаант, Тунхэл, Хэрх гэсэн 6 багтай. Хамгийн олон хүн амтай сум нь Мандал 27 162, аймгийн төв Сүхбаатар сум 22 911, Сайхан сум 9 375 байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээ 41 152.6 км², нэг хавтгай дөрвөлжин км квадратд тайлбайд 2.6 хүн ногддог. Хүн амын нягтрал хамгийн их нь Сүхбаатар сум 1 км²-д 504.6 хүн ногдож байна.

2. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**2.1 Хүн ам**

2017 оны жилийн эцэст суурин хүн амын тоо 108 768 -д хүрсэн нь өмнөх оноос 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 50.6, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 49.4 байгаа бол 0-14 насны хүүхэд 29.1, 15-59 насны хүн 63.9, 60-аас дээш насны хүмүүс 7.0 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээгээр 566 хүн гэрлэлтээ батлуулж, 141 хүн гэрлэлтээ цуцлуулж, 57 хүүхэд үрчлэгджээ. 2017 онд манай аймагт бусад аймаг хотоос бүгд 1 563 хүн шилжин ирж, 1 383 хүн шилжин явсан байна. Нийт шилжин ирэгсдийн 85.3 хувь нь Улаанбаатар хот, Дархан –уул, Орхон аймгаас, шилжин явагсдын 24.4 хувь нь Улаанбаатар хот, Дархан –Уул, Орхон аймагт явжээ.

Сэлэнгэ аймгийн хүн амын нас хүйсийн, суварга



Аймгийн хэмжээгээр 4 758 хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа бөгөөд нийт дүнгийн 45.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Энэ оны эцсээр аймгийн хэмжээгээр хагас өнчин хүүхэд 1 456, бүтэн өнчин 143, өрх толгойлсон хүүхэдтэй гэр бүлгүй хүн 4 112 байгаа ба үүнээс 2 786 нь гурав хүртэлх хүүхэдтэй өрх байна.



Эрүүл мэнд

Сэлэнгэ аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад их эмч 235, эм зүйч 27, тусгай мэргэжлийн 607 мэргэжилтэн тус тус ажиллаж байна.


2017 онд аймгийн хэмжээгээр нийт 1 712 эх төрж, 1 720 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 6.2 хувиар буурчээ.

Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 539, 20-24 насны 419, 30-34 насны 347, 35-39 насны 221, 40-44 насны 45, 20 хүртэлх насны 110 эх төрсөн байна.

Энэ онд 2 367 жирэмсэн шинээр хяналтанд орсны 82.1 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд авсан байна. Шинээр хяналтанд авсан жирэмсний 94.9 хувийг цусны шинжилгээнд хамруулснаас 47.1 хувьд нь сум, тосгодын эмнэлэгүүдэд гемоглобины тестээр шинжилсэн ба шинжилгээнд орсон 2 199 жирэмсний 2.1 хувьд нь цус багадалт илэрчээ.

Нас барсан хүний тоо 494 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 76 хүнээр буюу 13.3 хувиар өссөн байна. 0-1 хүртэлх хүүхдийн эндэгдэл 19, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Нийт нас баралтын шалтгааны 13.1 хувь нь осол гэмтлийн, 24.8 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна.

Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд



Халдварт өвчнөөр 779 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 57.9 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчний 58.7 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 25.3 хувийг сүрьеэ, 16.0 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.



2017 онд нийт 364 683 үзлэг хийсний 27.4 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 7.8 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 14.7 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 32 477 дуудлаганд үйлчилсний 14.3 хувийг алсын дуудлагаар үйлчилж яралтай тусламж үзүүлсэн.



2.3 Боловсрол

2017- 2018 оны хичээлийн жилд 35 сургуульд 1 024 үндсэн багш ажиллаж байгаа ба үүнээс эмэгтэй үндсэн багш 843 байна. Нийт 18 937 сурагчид суралцаж байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 9 388 сурагчид сурч байна. Энэ хичээлийн шинэ жилд 2 157 хүүхэд шинээр нэгдүгээр ангид элсэн орж, албан бус сургалтанд нийт 519 сурагч суралцаж байна.


Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрт 10 133 хүүхэд хамрагдаж 891 450.3 мян.төг зарцуулжээ. Ерөнхий боловсролын сургуульд 1 688 нийт ажиллагсад ажиллаж байгаа бөгөөд эмэгтэй 1 331 ажиллагсад байна.

Аймгийн хэмжээнд 43 цэцэрлэгийн 280 бүлэгт 291 багш багшилж, 8 549 хүүхэд хүмүүжиж байна.

Тайлангийн хугацаанд биеийн тамир, спортын 167 секци дугуйлан хичээллэж, 2 670 хүн хамрагджээ. Мөн хугацаанд улс, тив, дэлхий, нэрэмжит тэмцээнээс 136 медаль авсан байна.

2017 оны байдлаар аймгаас хүүхэд багачуудын дунд хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр зохиосон 6 удаагийн арга хэмжээнд 335 хүүхэд хамрагджээ. Улсын чанартай уралдаан тэмцээнээс 61 хүүхэд медаль авчээ.

Үндсэн багш, нийт сурагчдын тоо, сүүлийн 5 жилийн байдлаар




2.4 Хөдөлмөр

2017 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 824 болсон нь өмнөх оны мөн үеийнхээс 18.8 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 43.7 хувийг ерөнхий боловсролтой, 35.0 хувийг дээд боловсролтой, 13.1 хувийг мэргэжилтэй ажилчид, 7.5 хувийг тусгай дунд боловсролтой, 0.7 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 46 хүн ажилд зуучлагдан орж, 43 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 83 хүн шинээр бүртгэгдсэн байна. Шинээр 1 011 ажлын байр бий болж хөдөө аж ахуй, ан агнуур ой аж ахуй загас агнуур хувь, боловсруулах үйлдвэр, худалдаа гэр ахуйн засвар үйлчилгээ, боловсролын салбар тус тус 77.2 хувийг эзлэж байна.



Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшингээр




2.5 Нийгмийн даатгал, халамж

2017 оны байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 15 994 тэтгэвэр авагчдад 55 132.6 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 7 365 хүнд 2 515.6 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулга, өвчтөн сахисны тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 305 хүнд 1 109.7 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 568 хүнд 805.1 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 5 363.1 сая төгрөгийн зардлыг тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 37 149 хүнд 9 861.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая.төг



2.6 Гэмт хэрэг


2017 оны байдлаар Цагдаагийн газрын мэдээгээр нийт 729 гэмт хэрэг бүртгэгдсэний 230 нь согтуугаар үйлдэгдсэн ба гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувиар өсч гэмт хэргийн илрүүлэлт 67.3 хувьтай байгаа нь



өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс Ерөө, Мандал, Сайхан, Хүдэр, Сүхбаатар сумдад гэмт хэрэг 6-37 гаралтаар буюу 7-22.4 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 24.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 36.2 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 6.8 хувийг нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 13.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 23.6 хувийг малын хулгай эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр




2.7 Хилээр орсон, гарсан иргэд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 716 490 зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 53.8 хувиар буурсан байна. Нийт зорчигчдын 83.1 хувь нь Монгол иргэд, 16.9 хувь нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 50.5 хувиар, гадаад иргэдийн тоо 21.1 хувиар буурсан байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 56 470 хүн зорчсон байна.



Хилээр орсон, гарсан иргэд




3. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

Аймгийн 2016 оны дотоодын нийт бүтээгдэхүүн 562.7 тэрбум төгрөг болж, 2015 оны дүнгээс 2.0 хувиар буурсан байна. Аймгийн нэг хүнд 5.3 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн ногдож байна. 2016 оны дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбар 261.4 сая.төг буюу 46.5 хувь, хөдөө аж ахуйн салбар 145.5 сая.төг буюу 25.9 хувь, үйлчилгээний салбар 155.8 сая.төг буюу 27.6 хувийг тус тус эзэлж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн салбарт эзлэх хувь




3.2 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр энэ сард кассын цэвэр орлого 53 725.2 сая төгрөг, цэвэр зарлага 52 492.5 сая төгрөгт хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл 232 111.5 сая төгрөг байгаа ба үүний 2.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 77 314.9 сая төгрөг байна




Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төг/



3.3 Төрийн сан, татвар

2017 оны төсвийн гүйцэтгэлийн 12-р сарын мэдээгээр аймгийн төсвийн орлого 109.3 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 100.0 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, аймгийн Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 95.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ /сая.төг/



Татварын орлогын гүйцэтгэл 27 371.6 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 119.6 хувьтай байна. 2017 онд 299 аж ахуйн нэгж байгууллага шинээр бүртгэгдэж, 16 аж ахуйн нэгж, байгууллага татан буугдан нийт 3 379 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байна.


НӨАТ-ын урамшууллын систем аймгийн хэмжээнд 360 неат суутган төлөгч байгууллага, 199 пос, 506 Е-баримт хэвлэгч машин ажиллаж байгаа. Мөн цахимд холбогдох боломжтой 1 006 аж ахуйн нэгж, байгууллагууд байна. Мөн 2017 оны эхний 11 сарын байдлаар татвар төлөгч иргэд цахим төлбөрийн баримтын системд 9 удаагийн сугалааны тохирлоор Сэлэнгэ аймгаас нийт 901 иргэн азтан тодорч, 28.0 сая төгрөгийн сугалааны урамшуулал олгосон байна.



3.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2017 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 234.6 сая ам доллар, үүнээс экспорт 2.6 сая ам доллар, импорт 231.8 сая ам ам доллар байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ БАРАА ЭРГЭЛТ, САЯ.\$



3.4 Үнэ

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2017 оны 12 сард өмнөх сараас 3.0 хувиар, өмнөх оны мөн үеийнхээс 9.1 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа 7.8 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисны бүлгийн үнэ 5.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 8.1 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 15.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 13.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 10.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 10.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 8.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 6.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Харин хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 12 дугаар сард өмнөх сараас 3.0 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.6 хувь, орон сууц, ус цахилгаан хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 23.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 2.0 хувь, тээврийн бүлгийн үнийн дүнгээрээ 0.7 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 7.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ХАА-н бүтээгдэхүүний үнэ.

2016 оны мөн үеэс малын үнэ 20 000-210 000 төгрөгөөр буурсан байна. Түүхий эдийн хувьд хонины арьс 4 000 төгрөг, ямааны арьс 25 000 төгрөг, үхрийн шир 15 000-35 000 төгрөг, адууны шир 20 000 төгрөгөөр тус бүр худалдаалагдаж байна.



Хэрэглээний үнийн аймгийн индекс 2017 оны 12 дугаар сард (өмнөх сар = 100%)



4. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1 Бизнес регистрийн сан

Статистикийн бизнес регистрийн санд 2017 оны эхэнд 3 058 аж ахуйн нэгж бүртгэлтэй байсан бөгөөд 263 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлж, 5 аж ахуйн нэгж татан буугдан оны эцэст бүртгэлтэй 3 316 аж ахуйн нэгж, байгууллага байна.



4.2 Хөдөө аж ахуй

2017 онд аймгийн нийт малын тоо 1 509 925 толгой болж урьд оноос 89.8 мянган толгой буюу 5.6 хувиар буурсан нь 1 хүнд 13.9 толгой мал ногдож байна. Нийт малтай өрхийн тоо 9 541 болсон нь 2016 онтой харьцуулахад 24 өрхөөр хасагдсан байна. Үүний дотор малчин өрхийн тоо 4 679 болсон нь урьд онтой харьцуулахад 252 өрхөөр нэмэгдсэн байна.

Жилийн эцсийн байдлаар шувуу 11 443, гахай 4 559, зөгийн бүл 4 358 тоологджээ. Урьд оны мөн үетэй харьцуулахад шувуу 749 толгойгоор, зөгий 21 бүлээр тус бүр буурч, гахай 738 толгойгоор өссөн байна. Мөн 610.1 мянган ширхэг өндөг, 67.6 тонн гахайн мах, 101.7 тонн зөгийн бал бэлтгэжээ.

2017 оны мал тооллогын дүнгээр аймгийн дүнгээр 200 хүртэлх малтай 7171 өрх, 201-999 хүртэлх малтай 2 220 өрх, 1 000 болон түүнээс дээш малтай 150 өрх тоологджээ.

554.5 мянган эх мал төллөсөн нь урьд оны мөн үеэс 45.3 мянган толгойгоор бага ба Сант, Сүхбаатар, Сайхан сумдад төллөлтийн хувь өндөр буюу 90.8-96.6 хувьтай байна.

529.9 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 69.0 мянган толгой буюу 11.5 хувиар бага байна.


2017 онд оны эхний нийт малын 4.35 хувьтай тэнцэх 69 610 толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 20.7 дахин өсчээ. Хорогдсон нийт малын 11.9 хувийг өвчнөөр хорогдсон, 31.1 хувь нь хээлтэгч малын хорогдол байна.

Хорогдсон нийт малын 43 714 толгой буюу 62.8 хувь нь Ерөө, Орхонтуул, Цагааннуур, Хүдэр, Жавхлант сумдад ногдож байна.

2017 онд малын халдваргүй өвчнөөр 523 мал өвчилснөөс 11 нь хорогдож, 512 нь эдгэрсэн байна.




Нийт мал /мян.тол/



2017 оны мэдээгээр аймгийн хэмжээнд 157.7 мян.га-д үр тариа, 2.57 мян.га-д төмс, 2.5 мян.га-д хүнсний ногоо тус тус тариалжээ. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 10.4 мян.га буюу 7.1 хувиар их, төмс 0.69 мян.га буюу 22.3 хувиар, хүнсний ногоо 0.02 мян.га буюу 0.9 хувиар тус бүр бага тариалсан байна.


2017 оны ургац хураалтын мэдээгээр үр тариа 152.0 мян.тн, төмс 28.5 мян.тн, хүнсний ногоо 30.8 мян.тн хураан авчээ. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 92.6 мян.тн буюу 37.8 хувиар, төмс 14 мян.тн буюу 32.9 хувиар, хүнсний ногоо 1.9 мян.тн буюу 32.9 хувиар тус бүр бага ургац хураан авсан байна. 2017 онд аймгийн хэмжээнд 128.2 мян.га-д уринш бэлтгэсэн байна.

Ургац хураалт төмс, хүнсний ногоо /мян.тн/



4.3 Аж үйлдвэр

2017 онд аж үйлдвэрийн салбарт 305.8 тэр.бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 394.1 тэр.бум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеийнхээс үйлдвэрлэлт 0.6 хувиар буюу 1.9 тэр.бум төгрөг, борлуулалт 41.0 хувиар буюу 114.7 тэр.бум төгрөгөөр тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 25.8 хувь нь хүнсний салбарт 54.5 хувь нь уул уурхайн салбарт, 17.0 хувь нь барилгын материалын салбарт, 2.7 хувийг бусад салбарт бүтээгджээ. Сумдын жижиг дунд үйлдвэрүүд аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.4 хувьтай тэнцэх 1 189.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1 370.8 сая.төгрөгийн борлуулалт хийжээ. 2017 оны байдлаар аж үйлдвэрийн салбарт нийт 2 739 ажиллагсад ажиллаж байна. Үүний 22.5 хувь буюу 618 нь эмэгтэйчүүд эзэлж байна.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэр.бум төг)****4.4 Авто тээвэр****➤ Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээ**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд энэ онд суудлын 8 587, ачааны 6 105, тусгай 351, цистерн 262, зүтгүүр 181, механизм 371, чиргүүл 327, мотоцикл 1 463 нийт 23 350 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. 2017 онд 3 292 тээврийн хэрэгсэлд шилжилт хөдөлгөөн хийснээс эзэмшигч өөрчилж гэрчилгээ сольсон 2 813, улсын дугаар сольсон 944, тээврийн хэрэгслийн гэрчилгээ сольсон 3 141, тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхсөн 148, өнгө сольсон 22, автомашины хөдөлгүүр сольсон 1 хийгдсэн байна. Мөн импортоор орж ирсэн 161 мотоциклд шинээр улсын дугаар олгосон байна.

Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлтэй холбогдуулан сүүлийн 4-с дээш жил татвар төлөөгүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй болон эвдэрч ашиглагдахгүй болсон тээврийн хэрэгслүүдийг бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулж 2017 онд 315 тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулан ажилласан байна.

➤ Техникийн хяналтын үзлэг оношилгоонд орсон тээврийн хэрэгслийн мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2017 онд суудлын 8 587, чиргүүл 522, мотоцикль 644, ачаа, автобус 6 105 нийт 15 858 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдсан байна.

Авто тээврийн үндэсний төвөөс гарган өгсөн 2017 оны жилийн төлөвлөгөөний дагуу 16 220 тээврийн хэрэгсэл техникийн үзлэгт хамруулахаас 15 858 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулж 2017 оны жилийн төлөвлөгөөг 2.2%-иар бууруулан ажилласан байна.

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ**5.1 Цаг уур орчны мэдээ****ТАНЫ АНХААРАЛД**

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур болон орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн 4 бүс нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах,



хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд “зарим газраар”, 30-70 хувьд “ихэнх нутгаар”, 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд “бүх нутгаар” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 00-аас бага болж хүйтрэхийг “цочир хүйтрэл” гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээр аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд “Урьдчилан анхааруулах мэдээ”, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин ноцтой бэрхшээл учруулж эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гаргаж “Харанга” дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад яаралтай хүргэдэг. Засаг дарга нар “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харъяа нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаархи мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газарт, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор тус тус ирүүлнэ. Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаархи мэдээллийг Улаанбаатар хотын 326606, 326609 утсаар өгөх юмуу “УБ-46, Жуулчны гудамж-5, Ус цаг уурын хүрээлэнгийн “Урьдчилан мэдээлэх сектор” гэсэн хаягаар ирүүлнэ.

Уур амьсгалын тойм ***Climate review***

Нэгдүгээр сарын агаарын температурын уур амьсгалын дундаж нь бүх сумдын нутгаар 20-28 градус хүйтэн байдаг боловч сүүлийн 20 гаруй жилийн байдлаар 1981, 1984, 2000, 2005, 2008, 2010, 2011 онуудад ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 2-10 градусаар хүйтэн болж, шөнийн үнэмлэхүй бага температур 38-44 градус хүрч хүйтэрсэн бол 1982, 1985, 1986, 1989, 1992, 1994, 1999, 2002, 2006, 2007, 2015 онуудад ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 1-7 градусаар дулаан байж, өдөртөө 1 градус хүйтнээс 5 градус хүрч дулаарч байжээ.

Энэ сард уур амьсгалын дунджаар ихэнх сумдын нутгаар 2-4 мм, бусад сумдын нутгаар 2 мм хүртэл цас ордог боловч 1980, 1982, 1993, 1995, 1999, 2006, 2002, 2010 онуудад ихэнх нутгаар уур амьсгалын дунджаас 1-4 дахин их цас оржээ. Уур амьсгалын дундаж байдлаар нутгийн хойд 10-15 см, бусад нутгаар 4-9 см зузаан цас тогтдог боловч цас их орсон жилүүдэд цасны дундаж зузаан 40-60 см-т хүрч мал өвөлжилтийн байдал онцгой хүндэрч байжээ. Салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол жил бүр 1-3 удаа ажиглагддаг.



ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Weather forecast



Энэ сарын агаарын температурын дундаж нь Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голуудын хөндийгөөр 26-31 градус, бусад сумдын нутгаар 18-23 градус хүйтэн буюу олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар хүйтэн байх төлөвтэй /1 дүгээр зураг/.

Нэгдүгээр арав хоногийн эхээр хүйтний эрч бага зэрэг суларч Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голын хөндийгөөр шөнөдөө 29-34 градус, өдөртөө Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голуудын хөндийгөөр 17-22 градус хүйтэн, бусад сумдын нутгаар шөнөдөө 21-26 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн байна. Харин хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхээр хүйтний эрч чангарч шөнөдөө Орхон-Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голын хөндийгөөр 41-46 градус, өдөртөө Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голын хөндийгөөр 25-30 градус хүйтэн, бусад сумдын нутгаар шөнөдөө 31-36 градус, өдөртөө 21-26 градус хүйтэн байна. Бусад хугацаанд Орхон-Сэлэнгэ, Хараа, Ерөө, Туул голын хөндийгөөр шөнөдөө 32-37 градус, өдөртөө 18-23 градус хүйтэн, бусад сумдын нутгаар шөнөдөө 23-28 градус, өдөртөө 13-18 градус хүйтэн байна Энэ сард орох цасны хэмжээ нь дунжийн орчим байх төлөвтэй. /2 дугаар зураг/.

Нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн сүүлч гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, дунд үеэр нутгийн зүүн хэсгээр цас орно. Энэ үеэр салхи зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсч зөөлөн цасан шуурга шуурах төлөвтэй.

01-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

1-р сарын хур тунадасны урьдчилсан мэдээ



Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчины шинжилгээний албаны Байгаль орчины шинжилгээний лабораторын 2017 оны 4-р улиралд Орхон голын дунд, эцсийн цэг, Сэлэнгэ -12 зөрлөгөөс авсан дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд гадаргын усны MNS 4586;98 стандартын дагуу байна. Агаарын чанарын Сүхбаатар харуулын орчимд хийсэн шинжилгээ стандартын дагуу байгаа боловч галлалгаатай үеийн явуул судалгаагаар вокзол орчимд азотын давхар исэл 0.044 мг\м³, хүхэрлэг хий 0.010 мг\м³ байна. Энэ нь өдөр тутамын шинжилгээний дүнтэй харьцуулхад азотын давхар ислийн хэмжээ 2.0 дахин, хүхэрлэг хий агууламж 2.0 дахин их гарсан байна.

5.2. Ойжуулалт, тарьц, нөхөн сэргээлтийн мэдээ

Аймгийн хэмжээнд 17 сумын 60 гаруй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр мод үржүүлгийн газрууд 20



гаруй төрлийн 11.0 сая ширхэг тарьц, суулгац бойжуулан ургуулж байна. 2017 онд нийт 99.4 га талбайд нөхөн сэргээлт хийснээс 72.4 га талбайд техникийн, 27.0 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ойжуулсан талбай 200 га, мод бэлтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө 599.4 га, гадаадын хөрөнгөөр ойжуулсан талбай 27.0 га, уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн дүйцүүлсэн хамгаалал 10 га, улсын төсвийн хөрөнгөөр 10 га, дотоодын төрийн бус байгууллагуудын хөрөнгөөр 20.5 га нийт 866.9 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгүүлсэн.

5.3. Агаар, усны бохирдлын мэдээ

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны байгаль орчны шинжилгээний лабораторийн 2017 оны 4-р улиралд Орхон голын дунд, эцсийн цэг, Сэлэнгэ -12 зөрлөгөөс авсан дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд гадаргын усны MNS 4586;98 стандартын дагуу байна. Агаарын чанарын Сүхбаатар харуулын орчимд хийсэн шинжилгээ стандартын дагуу байгаа боловч галлалгаатай үеийн явуул судалгаагаар вокзол орчимд азотын давхар исэл 0.044 мг\м³, хүхэрлэг хий 0.010 мг\м³ байна. Энэ нь өдөр тутамын шинжилгээний дүнтэй харьцуулхад азотын давхар ислийн хэмжээ 2.0 дахин, хүхэрлэг хий агууламж 2.0 дахин их гарсан байна.

6. БУСАД

а . Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар энэ онд 1 249 аж ахуйн нэгж байгууллага, 683 иргэнд хяналт, шалгалт хийж, 2 663 зөрчил дутагдал илрүүлж, 1 768 зөрчил арилгуулсан байна.

2017 онд Сэлэнгэ аймгийн төрийн Аудитын газар гүйцэтгэлийн аудитыг 88 аж ахуйн нэгж, байгууллагад, нийцлийн аудитыг 424 аж ахуйн нэгж, байгууллагад, Санхүүгийн аудитыг 304 аж ахуйн нэгж, байгууллагад хийж нийт 237 зөрчил илрүүлсэн байна.

2017 онд Санхүү хяналт, аудитын алба нийт 82 аж ахуй нэгж, байгууллагад хяналт, шалгалт хийж 184 зөрчил илрүүлж, 250 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж өгч ажилласан байна.

б. Онцгой байдлын газрын мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд он гарсаар 570 объект, 1 758 айл өрх үзлэг шалгалтанд хамрагдаж, 1 920 зөрчил илрүүлэн, 418 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2017 онд 113 гал түймэр гарч 474.1 сая төгрөгийн хохирол учирсан байна.

с. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба

Сум дундын 20-р шүүхийн мэдээгээр энэ онд 921 хэрэг шийдвэрлэснээс 199 нь эрүүгийн хэрэг, 688 нь иргэний хэрэг, 34 нь захиргааны хэрэг байна. 4-р улирлын байдлаар бүгд 201 хүн ял шийтгүүлсэн ба үүний 26 нь эмэгтэй байна. Мөн 373 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч 371 буюу 99.4 хувиар шийдвэрлэжээ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд оны эхний үлдэгдэл 279 гүйцэтгэлийн материал байсан бөгөөд энэ онд 312 материал нэмэгдэж, 25 материал хасагдсан бүгд 566 гүйцэтгэлийн материалаар 3769.1 сая төгрөгийн өрийг барагдуулахаас 309 гүйцэтгэлийн материалаар 1 117.6 сая төгрөгийн өрийг бодитой барагдуулжээ.



2017 онд ШША-ны криминалистик шинжээч нар 70 шинжилгээ хийж, 711 хэргийн газарт үзлэг хийхэд оролцсон байна. Шүүхийн шинжилгээний эмнэлэг нь 795 удаа хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, 190 цогцост шинжилгээ хийлээ.

d. Стандарт хэмжил зүйн хэлтэс

2017 оны жилийн эцсийн байдлаар 5 280 хэмжих хэрэгсэл баталгаажуулснаас механик 937, цахилгаан 3 771 эзэлхүүн 491, дулаан даралт 81 хэмжих хэрэгсэл байна. Бүтээгдэхүүний гэрчилгээ 10, үйлчилгээний гэрчилгээ 265 тус тус олгосон байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 5 итгэмжлэгдсэн лаборатори байдаг ба нийт 68 иргэд, аж ахуйн нэгж стандартын салбар сангаар үйлчлүүлсэн байна.

e. Оюуны өмч, Улсын бүртгэлийн газар

2017 онд Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээгээр төрөөс хувьчилсан орон сууц өмлөх эрхийн баталгаажуулалтыг 29 иргэн, газраас бусад ҮХЭХӨЭ-н анхны бүртгэл, баталгаажуулалтыг 570 иргэн баталгаажуулж 4 гэмтээсэн гэрчилгээг, 32 үрэгдүүлсэн гэрчилгээг тус тус шинээр олгож, 2 158 иргэн лавалгаа, хуулбар хийлгэж, нийт 1 619 гэрчилгээ бичигдсэн байна. Мөн Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээгээр 6 917 мэдүүлэг хүлээн авч, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг 1 938 иргэн, газар эзэмших, ашиглах эрхийг анх удаа 11 иргэн тус тус баталгаажуулсан байна. Өмчлөх эрх шилжих гэрээ 696 хийгдсэнээс худалдах, худалдан авах гэрээ 330, бэлэглэх гэрээ 116, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөх гэрээ 76 хийгдэж, 1 гэмтээсэн гэрчилгээг, 24 үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгож нийт 2 876 гэрчилгээ бичигдсэн байна. Оюуны өмч, Улсын бүртгэлийн газрын мэдээгээр 2017 онд нийт үйлчилгээний хураамж 181.6 сая төгрөг, ҮХЭХӨЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 227.5 сая төгрөг төвлөрсөн байна.

f. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар

2017 онд газар өмчлөх тухай өргөдөл 1 509 иргэн гаргаснаас 149 иргэн нь одоо эзэмшиж ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчлөхийг хүссэн, 1 159 иргэн нь шинээр газар өмчилж авахыг хүссэн, улсын чанартай зам дагуу газрыг өмчлөхийг хүссэн 200 иргэн, аж ахуйн зориулалтаар газар өмчлөхийг хүссэн өргөдөл 1 иргэн тус тус гаргасан байна.

Засаг даргын захирамжаар 1 913 иргэнд 272.3 га газар өмчлүүлэхээр шийдвэрлэсэн ба үүний 121 иргэнд одоо ашиглаж байгаа 19 га газраа, 1 531 иргэнд 234.7 га газар шинээр, 259 иргэнд улсын чанартай зам дагуу 18.4 га газар, 2 иргэнд аж ахуйн зориулалтаар 0.19 га газар тус тус өмчилж авсан байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 1 293 нэгж талбар барьцаа бүртгэлт бүргүүлснээс 804 нэгж талбарыг иргэн, 489 нэгж талбарыг аж ахуй нэгж бүртгүүлсэн байна. Мөн 236 иргэний нэгж талбар, 30 аж ахуй нэгжийн барьцааг бүртгэлээс тус тус чөлөөлсөн байна.

2017 оны байдлаар нийт 347 338.8 га талбайд хохирол учирсны 6 295.1 га буюу 1.8 хувийг тариалангийн газар, 99 787 га буюу 28.7 хувийг бэлчээр ба бусад өвслөг ургамал газар, 477.7 га буюу 0.1 хувийг хот тосгон, бусад суурин газар, 235 108.2 га буюу 67.8 хувийг ойн сан бүхий газар, 5 670.7 га буюу 1.6 хувийг уурхайн эдэлбэр газар тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар нийт 134 242.8 га талбайд газар хамгаалах арга хэмжээ авсан ба үүний 52 650.0 га буюу 39.2 хувийг тариалангийн газарт, 15 584 га буюу 11.6 хувийг бэлчээр ба бусад өвслөг ургамал газарт, 241.3 га буюу 0.2 хувийг хот тосгон, бусад суурийн газарт, 65 332.4 га буюу 48.7 хувийг ойн сан бүхий газарт, 351 га буюу



0.2 хувийг усны сан бүхий газарт, 84.1 га буюу 0.1 хувийг уурхайн эдэлбэр газарт тус тус авсан байна.

г. Түүвэр судалгаа

2017 онд Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс Үндэсний Статистикийн Хорооны нэгдсэн арга зүйн дагуу Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 408 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 480 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 3 090.0 мянган төгрөг олгосон байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ГҮНДЭГМАА



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жилийн эцсийн байдлаар
1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР

1.1 СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Сумын нэр	Багийн тоо	Нутаг дэвсгэрийн хэмжээ	Хүн амын нягтшил	Сүхбаатар сумаас хүрэх урт км-ээр
ДҮН	56	41 153	2.6	-
1. Бэлчирийн бүс				
А.Сүхбаатар	8	45	504.6	-
Б.Алтанбулаг	3	2 100	2.4	24
В.Шаамар	3	672	4.7	22
Бүсийн төв Сүхбаатар				
2.Ерөөгийн бүс				
А.Ерөө	3	8 204	0.8	90
Б.Хүдэр	2	2 839	0.9	160
В.Жавхлант	2	1 190	1.8	65
Бүсийн төв Ерөө				
3.Хараагийн бүс				
А.Мандал	9	4 844	5.6	230
Б.Баянгол	3	1 976	2.8	175
Бүсийн төв Мандал				
4.Орхоны бүс				
А. Сайхан	3	1 312	7.2	160
Б.Сант	2	1 387	1.6	190
В.Орхон	2	1 306	1.8	175
Г.Орхонтуул	3	2 941	1.3	240
Д.Баруунбүрэн	3	2 815	1.1	220
Е.Хушаат	2	2 010	0.99	90
Бүсийн төв Сайхан				
5.Сэлэнгийн бүс				
А.Зүүнбүрэн	3	1 205	2.4	45
Б.Цагааннуур	3	3 815	1.3	90
В.Түшиг	2	2 493	0.8	135
Бүсийн төв Цагааннуур				

1.2 ТОМООХОН ГОЛ, НУУР, УУЛ, ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

Үзүүлэлт	Сумын нэр	Нэр
1.Хамгийн жнджр уул "далайн төвшнээс дээш 2 233.1м"	Мандал	Чин уул
2. Хамгийн нам дор газар " далайн төвшнээс дээш 601 м"	Сүхбаатар	Орхон -сэлэнгийн бэлчир
3.Хамгийн урт гол "Орхон 350км"	Сэлэнгэ аймаг	Орхон гол
4.Хамгийн том нуур " Цагааннуур 2.7км2"	Цагааннуур	Цагаанн нуур
5.Улсын тусгай хамгаалалттай газар 616 645 га	Сэлэнгэ аймаг	Хан хэнтийн
6. Байгалийн цогцолбор газар 70 805 га	Сэлэнгэ аймаг	Тужийн нарсны

Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын газар

**2. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****2.1 Хүн ам****2.1.1 СУУРИН ХҮН АМЫН ТОО, сумдаар**

Сумын нэр	2014-XII	2015-XII	2016-XII	2017-XII
Дүн	105 253	104 725	106 677	108 768
Алтанбулаг	5 030	4 729	5 052	5 089
Ерөө	6 578	6 393	6 494	6 752
Зүүнбүрэн	2 725	2 704	2 756	2 832
Мандал	25 693	26 600	26 880	27 162
Орхон	2 350	2 306	2 369	2 376
Сант	2 184	1 961	2 094	2 169
Цагааннуур	4 716	4 687	4 783	5 011
Баянгол	5 594	5 403	5 516	5 608
Сайхан	9 177	9 130	9 325	9 375
Орхонтуул	3 667	3 621	3 680	3 778
Баруунбүрэн	3 043	3 111	3 197	3 184
Шаамар	3 943	3 959	3 858	3 874
Хүдэр	2 232	2 384	2 424	2 490
Сүхбаатар	22 669	22 238	22 482	22 911
Жавхлант	2 071	1 974	2 099	2 164
Түшиг	1 710	1 694	1 739	2 004
Хушаат	1 871	1 831	1 929	1 989

Эх үүсвэр: Аймгийн хүн амын жилийн эцсийн мэдээ

2.1.2 ХҮН АМЫН ТОО, нас, хүйсээр

Насны бүлэг	Бүгд	Хүйс		Хүйсийн харьцаа
		Эрэгтэй	Эмэгтэй	
Дүн	108 768	55 067	53 701	103.0
0-4	11 926	6 080	5 846	104.0
5-9	11 422	5 823	5 599	104.0
10-14	8 309	4 301	4 008	107.0
15-19	8 625	4 359	4 266	102.0
20-24	8 415	4 430	3 985	111.0
25-29	9 874	5 342	4 532	118.0
30-34	8 603	4 543	4 060	112.0
35-39	7 940	4 146	3 794	109.0
40-44	7 591	3 915	3 676	107.0
45-49	7 009	3 319	3 690	90.0
50-54	6 397	3 052	3 345	91.0
55-59	5 092	2 398	2 694	89.0
60-64	3 223	1 530	1 693	90.0
65-69	1 852	844	1 008	84.0
70-74	1 069	434	635	68.0
75-79	799	328	471	70.0
80+	622	223	399	56.0

Эх үүсвэр: Аймгийн хүн амын жилийн эцсийн мэдээ

**2.1.3 ХҮН АМЫН НАС, хүйсийн бүтэц**

Үзүүлэлтүүд	2014-XII	2015-XII	2016-XII	2017-XII
Дүн	105253	104725	106677	108768
Эрэгтэй	53019	53165	53942	55067
Эмэгтэй	52234	51560	52735	53701
Насны бүлгээр 0-14	28578	30390	30846	31657
15-59	70142	67756	68751	69546
60+	6533	6579	7080	7565
Эрэгтэйчүүдийн эзлэх %	50.4	49.6	50.6	50.6
Эмэгтэйчүүдийн эзлэх %	49.6	49.2	49.4	49.4
Насны бүтэц, хувиар				
0-14	27.2	29.0	28.9	29.1
15-59	66.6	64.7	64.4	63.9
60+	6.2	6.3	6.6	7.0
Хүйсийн харьцаа	98.5	97.0	97.8	97.5
Хүн ам зүйн ачаалал	50.1	54.6	55.2	49.5

2.1.4 ХҮН АМЫН ТОО, сумдаар, насны бүлгээр

Сумын нэр	Насны бүлэг									
	0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49
Сүхбаатар	2 543	2 340	1 640	1 704	1 465	2 125	1 896	1 612	1 682	1 556
Алтанбулаг	539	541	440	392	382	425	406	383	362	351
Баруунбүрэн	392	354	273	293	256	276	228	237	209	184
Баянгол	634	583	399	446	440	551	411	412	394	352
Ерөө	756	723	504	502	563	673	571	493	461	385
Жавхлант	224	237	172	153	184	180	176	172	148	134
Өүүнбүрэн	352	323	207	227	209	232	226	231	185	156
Мандал	2 916	2 803	2 135	2 127	2 132	2 486	2 185	2 021	1 846	1 695
Орхон	257	225	184	223	192	209	152	174	167	130
Орхонтуул	369	401	292	339	319	285	313	270	276	264
Сайхан	932	979	672	781	785	901	732	683	620	697
Сант	189	209	199	186	196	165	168	131	152	146
Түшиг	223	223	143	189	186	163	175	142	125	125
Хүдэр	285	270	182	185	185	226	183	183	191	173
Хушаат	225	235	152	172	152	135	170	169	161	134
Цагааннуур	642	579	415	407	482	460	358	358	359	276
Шаамар	448	397	300	299	287	382	253	269	253	251
Бүгд	11 926	11 422	8 309	8 625	8 415	9 874	8 603	7 940	7 591	7 009



Хүснэгт 2.1.4 –ын үргэлжлэл

Сумын нэр	Насны бүлэг									
	50-54	55-59	60-64	65-69	70-74	75-79	80-84	85-89	90-94	95-99
Сүхбаатар	1 447	1 141	742	442	251	185	91	42	7	0
Алтанбулаг	304	247	139	82	44	30	13	6	3	0
Баруунбүрэн	146	122	84	58	27	30	6	6	2	1
Баянгол	331	276	163	88	58	41	12	12	4	1
Ерөө	392	298	201	100	58	36	23	10	3	0
Жавхлант	119	103	77	43	19	12	10	1	0	0
Өүүнбүрэн	156	124	82	50	32	24	14	1	0	1
Мандал	1 524	1 292	838	476	282	219	121	46	16	2
Орхон	131	133	76	47	37	24	12	2	0	1
Орхонтуул	218	190	97	63	28	30	15	7	1	1
Сайхан	663	414	213	126	72	57	27	18	2	1
Сант	136	123	82	40	19	14	6	4	4	0
Түшиг	109	88	58	18	19	9	5	3	1	0
Хүдэр	144	104	84	52	19	15	5	3	1	0
Хушаат	101	60	54	33	17	12	5	1	1	0
Цагааннуур	237	186	110	59	39	22	10	8	3	1
Шаамар	239	191	123	75	48	39	11	6	3	0
Бүгд	6 397	5 092	3 223	1 852	1 069	799	386	176	51	9

Эх үүсвэр: Аймгийн хүн амын жилийн эцсийн мэдээ

2.1.5 ТӨРӨЛТ

Сумын нэр	Төрсөн эх				2017 - XII 2016 - XII
	2014 - XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII	
ДҮН	2 024	1 945	1 826	1 712	94
Алтанбулаг	1	4	1	2	2*
Ерөө	44	35	57	39	68
Зүүнбүрэн	2	5	9	3	33
Мандал	746	687	620	615	99
Орхон					
Сант					
Цагааннуур	17	26	6	14	2.3*
Баянгол	2	2	3	4	133
Сайхан	135	139	114	91	80
Орхонтуул	6	9	8	6	75
Баруунбүрэн	4	5	6	3	50
Шаамар	4	2	1	3	3*
Хүдэр	8	5	4	4	100
Сүхбаатар	1 031	1 006	972	911	94
Жавхлант	1	2		1	
Түшиг	18	17	20	16	80
Хушаат	5	1	5		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



2.1.6 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО

Сумын нэр	Амьд төрсөн хүүхэд								<u>2017-XII</u> 2016-XII
	2014 - XII		2015 - XII		2016 - XII		2017 - XII		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	2 029	963	1 956	958	1 836	862	1 720	849	94
Алтанбулаг	1		4	2	1	1	2	2	2*
Ерөө	43	5	37	22	57	29	40	29	70
Зүүнбүрэн	2		4	3	9	4	3	2	33
Мандал	750	148	689	330	629	265	622	291	99
Орхон									
Сант									
Цагааннуур	17	3	26	15	6	2	13	8	2.1*
Баянгол	2		2		3	1	4	2	133
Сайхан	134	32	137	71	114	66	91	48	80
Орхонтуул	6	2	9	4	8	7	6	2	75
Баруунбүрэн	3	1	5	1	6	3	3	3	50
Шаамар	4	1	2		1	1	3		3*
Хүдэр	8	1	5	2	4	3	4	2	100
Сүхбаатар	1 035	768	1 016	499	973	473	912	452	94
Жавхлант	1		2	1			1	1	
Түшиг	18		17	8	20	7	16	7	80
Хушаат	5	2	1		5				


Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

2.1.7 ТӨРСӨН ЭХ, боловсролоор

Үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII	<u>2017-XII</u> 2016-XII
Бүгд	2 024	1 945	1 826	1 712	94
-дээд боловсрол	417	414	360	409	114
-мэргэжлийн болон техникийн боловсрол	82	93	78	84	108
-дунд боловсрол	1 464	1 331	1 260	1 108	88
-бага боловсрол	44	74	101	91	90
-боловсролгүй	17	33	27	20	74

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Төрсөн эх, боловсролоор



**2.1.8 ТӨРСӨН ЭХ**, насны бүлгээр

Үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII	<u>2017-XII</u> <u>2016-XII</u>
Бүгд	2 024	1 945	1 826	1 712	94
20 хүртэлх	150	232	116	110	95
20 - 24	598	486	500	419	84
25 - 29	542	557	555	539	97
30 - 34	428	393	359	378	105
35 - 39	251	231	238	221	93
40 - 44	52	43	57	45	79
45 - 49	3	3	1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

2.1.9 НАС БАРАЛТ

Сумын нэр	Нас баралт								<u>2017-XII</u> <u>2016-XII</u>
	2014 - XII		2015 - XII		2016 - XII		2017 - XII		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	484	208	527	236	570	236	494	192	87
Алтанбулаг	26	15	23	14	25	14	21	9	84
Ерөө	34	13	40	18	51	12	39	11	77
Зүүнбүрэн	9	5	21	10	13	7	9	3	69
Мандал	125	47	146	64	130	46	122	41	94
Орхон	9	5	13	5	10	8	13	5	130
Сант	16	6	3	1	9	4	10	5	111
Цагааннуур	17	6	25	13	27	9	23	10	85
Баянгол	19	8	19	7	27	8	26	10	96
Сайхан	42	18	43	24	47	22	37	13	79
Орхонтуул	11	5	13	4	20	12	16	11	80
Баруунбүрэн	8	7	8	4	16	5	11	5	69
Шаамар	17	5	23	9	28	16	27	14	96
Хүдэр	13	2	19	6	15	6	11	1	73
Сүхбаатар	106	46	104	49	132	57	112	52	85
Жавхлант	13	6	10	3	7	1	7	1	100
Түшиг	9	4	9	2	8	5	6	0	75
Хушаат	10	10	8	3	5	4	4	1	80

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**2.1.10 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ**

Сумын нэр	0-1 хүртэлх насны хүүхэд			
	2014 - XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
Дүн	13	16	27	19
Алтанбулаг				1
Ерөө	1		3	2
Зүүнбүрэн				
Мандал	5	2	5	4
Орхон				
Сант				
Цагааннуур			1	2
Баянгол				1
Сайхан		3	1	
Орхонтуул		1		
Баруунбүрэн			1	
Шаамар		1	1	2
Хүдэр				
Сүхбаатар	7	9	15	7
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	1-5 хүртэлх насны хүүхэд			
	2014 - XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII
Дүн	5	5	8	7
Алтанбулаг				
Ерөө				2
Зүүнбүрэн				
Мандал	2		3	2
Орхон				
Сант			1	
Цагааннуур				1
Баянгол				
Сайхан				1
Орхонтуул				
Баруунбүрэн		1		
Шаамар	1	1		
Хүдэр			1	
Сүхбаатар	2	3	3	
Жавхлант				
Түшиг				1
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**2.1.11 НАС БАРАЛТ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2014 -XII	2015 - XII	2016 - XII	2017 - XII	$\frac{2017 - XII}{2016 - XII}$
Бүгд	485	527	570	494	86.7
үүнээс эмэгтэй	202	236	222	197	88.7
0 - 1	13	16	27	19	70.4
1 - 5	5	7	9	8	88.9
6 - 18	13	17	14	7	50.0
19 - 54	159	183	182	163	89.6
54 дээш	295	304	338	297	87.9

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

2.1.12 ӨРХИЙН ТОО, сумдаар

Сумын нэр	2014-XII	2015-XII	2016-XII	2017-XII
Дүн	30 040	29 316	29 521	29 912
Алтанбулаг	1 388	1 330	1 332	1 369
Ерөө	1 801	1 820	1 816	1 875
Зүүнбүрэн	900	797	797	865
Мандал	7 382	7 215	7 199	7 238
Орхон	746	734	753	848
Сант	698	630	751	644
Цагааннуур	1 301	1 297	1 319	1 368
Баянгол	1 675	1 615	1 616	1 623
Сайхан	2 589	2 630	2 653	2 656
Орхонтуул	1 010	1 008	1 009	1 032
Баруунбүрэн	851	891	909	920
Шаамар	1 335	1 157	1 115	1 119
Хүдэр	632	633	647	653
Сүхбаатар	5 995	5 845	5 811	573
Жавхлант	656	648	700	712
Түшиг	534	530	538	547
Хушаат	547	536	556	573

**2.1.13 ӨРХ, ХҮН АМЫН ТОО, багуудаар**

Сумын нэр	Д/д	Багын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Сүхбаатар	1	1-р баг, Хонгорморьт	596	2 023	1 015	1 008
	2	2-р баг, Цагаан-Эрэг	568	2 037	970	1 067
	3	3-р баг, Салхит	878	3 692	1 868	1 824
	4	4-р баг, Баянхаан	750	3 212	1 596	1 616
	5	5-р баг, Боргүвээ	869	3 686	1 855	1 831
	6	6-р баг, Орхон	685	2 342	1 145	1 197
	7	7-р баг, Ганөөм	822	3 107	1 461	1 646
	8	8-р баг, Буурхээр	702	2 812	1 396	1 416
		Сумын дүн	5 870	22 911	11 306	11 605
Алтанбулаг	9	1-р баг, Бүргэдтэй	614	2 340	1 167	1 173
	10	2-р баг, Суварга	495	1 869	955	914
	11	3-р баг, Цөх	260	880	471	409
		Сумын дүн	1 369	5 089	2 593	2 496
Баруунбүрэн	12	1-р баг, Ивэн	220	785	432	353
	13	2-р баг, Бургалтай	279	959	497	462
	14	3-р баг, Цагаан-Овоо	421	1 440	705	735
		Сумын дүн	920	3 184	1 634	1 550
Баянгол	15	1-р баг, Хараа	574	1 984	1 036	948
	16	2-р баг, Баян	592	2 030	1 035	995
	17	3-р баг, Гонир	457	1 594	820	774
		Сумын дүн	1 623	5 608	2 891	2 717
Ерөө	18	1-р баг, Тавин	429	1 585	839	746
	19	2-р баг, Буурагчин	589	2 053	1 039	1 014
	20	3-р баг, Бугант	857	3 114	1 610	1 504
		Сумын дүн	1 875	6 752	3 488	3 264
Жавхлант	21	1-р баг, Бумбат	336	1 015	541	474
	22	2-р баг, Моностой	376	1 149	609	540
		Сумын дүн	712	2 164	1 150	1 014
Зүүнбүрэн	23	1-р баг, Жаргалант	355	1 287	621	666
	24	2-р баг, Бэлчир	355	969	490	479
	25	3-р баг, Мангирт	155	576	275	301
		Сумын дүн	865	2 832	1 386	1 446
Мандал	26	1-р баг, Төмөр өам	981	3 377	1 657	1 720
	27	2-р баг, Ширхэнцэг	851	3 188	1 598	1 590
	28	3-р баг, Баянсуудал	1 001	4 070	2 066	2 004
	29	4-р баг, Хэрх	847	3 026	1 503	1 523
	30	5-р баг, Түнхэл	848	3 044	1 590	1 454
	31	6-р баг, Баянхангай	842	3 418	1 693	1 725
	32	7-р баг, Минжийн хангай	900	3 587	1 780	1 807
	33	8-р баг, Тарни	323	1 005	532	473
	34	9-р баг, Баян-Арцат	645	2 447	1 230	1 217



Хүснэгт 2.1.13 – ийн үргэлжлэл

Сумын нэр	Д/д	Багын нэр	Өрхийн тоо	Хүн амын тоо		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Орхон	35	1-р баг, Орхон	327	1 038	515	523
	36	2-р баг, Бэлэндалай	521	1 338	716	622
		Сумын дүн	848	2 376	1 231	1 145
Орхонтуул	37	1-р баг, Рашаант	480	1 831	992	839
	38	2-р баг, Баянцогт	380	1 342	694	648
	39	3-р баг, Хонгор-Овоо	172	605	330	275
		Сумын дүн	1 032	3 778	2 016	1 762
Сайхан	40	1-р баг, Хөтөл	760	2 797	1 380	1 417
	41	2-р баг, Гавшгай	1 261	4 561	2 253	2 308
	42	3-р баг, Номгон	635	2 017	1 101	916
		Сумын дүн	2 656	9 375	4 734	4 641
Сант	43	1-р баг, Ивэн	320	1 162	578	584
	44	2-р баг, Хушаат	324	1 007	550	457
		Сумын дүн	644	2 169	1 128	1 041
Түшиг	45	1-р баг, Жаргалмандах	287	1 074	581	493
	46	2-р баг, Ар нуга	260	930	487	443
		Сумын дүн	547	2 004	1 068	936
Хүдэр	47	1-р баг, Тарвагатай	335	1 339	707	632
	48	2-р баг, Баянцагаан	318	1 151	574	577
		Сумын дүн	653	2 490	1 281	1 209
Хушаат	49	1-р баг, Даагат	256	910	477	433
	50	2-р баг, Мөнхтолгой	317	1 079	576	503
		Сумын дүн	573	1 989	1 053	936
Цагааннуур	51	1-р баг, Оргих	267	1 060	536	524
	52	2-р баг, Хуурч	620	2 133	1 080	1 053
	53	3-р баг, Тийрэг	481	1 818	923	895
		Сумын дүн	1 368	5 011	2 539	2 472
Шаамар	54	1-р баг, Дэлгэрхаан	411	1 330	653	677
	55	2-р баг, Охиндий	236	799	399	400
	56	3-р баг, Дулаанхаан	472	1 745	868	877
		Сумын дүн	1 119	3 874	1 920	1 954
Аймгийн дүн			29 912	108 768	55 067	53 701

**2.1.14 ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, аймгийн дүнгээр, өрхөөр**

Үзүүлэлт	2016		2017	
	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь	Тоо	Нийт өрхөд эзлэх хувь
1. Аймгийн нийт өрхийн тоо	29 521	100.0	29 912	100.0
2. Сууцны төрлөөр: Гэрт	7 356	24.9	7 495	25.1
Байшинд	22 165	75.1	22 417	74.9
3.Сууцны нөхцөл: Бие даасан Тохилог сууцанд	385	1.3	387	1.3
Орон сууцны байшинд	3 969	13.4	4 021	13.4
Сууцны тусдаа байшинд	16 683	56.5	16 870	56.4
Гэр сууцанд	7 356	24.9	7 495	25.1
Нийтийн байранд	659	2.2	665	2.2
Бусад сууцанд	469	1.6	474	1.6
4.Халаалтын төрлөөр: Төвлөрсөн систем	5 106	17.3	5 164	17.3
Нам даралтын зуух	410	1.4	418	1.4
Цахилгаан халаагуур	82	0.3	80	0.3
Ердийн галлагаа	23 923	81.0	24 250	81.1
5. Цахилгаан хангамж: Төвлөрсөн систем	24 871	84.2	25 143	84.1
Бусад эх үүсвэр	4 532	15.4	4 629	15.5
цахилгааны эх үүсвэргүй	118	0.4	140	0.5
6. Усан хангамж: Төвлөрсөн усан хангамж	4 836	16.4	4 907	16.4
Бие даасан систем	695	2.4	702	2.3
Зөөврийн	23 990	81.3	24 303	81.2
7. Хатуу хог хаягдал: Үйлчилгээий байгууллагаар	12 790	43.3	13 017	43.5
Зөвшөөрөгдсөн цэгт	11 605	39.3	11 636	38.9
Тогтсон цэг байхгүй	5 126	17.4	5 259	17.6
8.Бохир ус зайлуулалт: Төвлөрсөн систем	4 473	15.2	4 528	15.1
Бие даасан систем	210	0.7	212	0.7
Бусад	24 838	84.1	25 172	84.2

**2.1.15 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумдаар**

Сумдын нэр	2014-XII	2015-XII	2016-XII	2017-XII
Дүн	1 430	1 398	1 639	1 563
Алтанбулаг	63	68	74	73
Ерөө	69	53	76	110
Зүүнбүрэн	30	31	35	41
Мандал	295	302	351	302
Орхон	34	26	37	26
Сант	29	29	32	51
Цагааннуур	30	43	51	55
Баянгол	67	94	89	98
Сайхан	199	149	190	168
Орхонтуул	50	50	51	60
Баруунбүрэн	57	50	36	50
Шаамар	45	54	52	65
Хүдэр	29	42	39	41
Сүхбаатар	333	307	401	332
Жавхлант	55	38	50	42
Түшиг	20	29	37	15
Хушаат	25	33	38	34

Эх үүсвэр: Аймгийн Оюуны өмч, Улсын бүртгэлийн газар

